

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 01/2020 • February 2020

After debates, the Parliament finally changes the scope of payments for mineral resources

Contacts:

Michael Ahern

Partner & TLS Leader
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts

Executive Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska

Senior Manager, Tax and Legal Services
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu

Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC

Central Tower 6th floor
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068

www.pwc.com/mn

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.
All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



The Parliament approves amendments to the Minerals Law with respect to royalties on usage of minerals resources.

On 26 March 2019, the Parliament amended (the "**Amendment**") Minerals Law*. The Amendment focused on the Article 47 of the Minerals Law and made changes in relation to *royalties* on usage of minerals resources (the "**Royalty**") applied on selling, transporting for selling or using minerals. The Amendment also expanded the scope of entities who are subject to paying the Royalty by including not only mineral license holders, but also entities who engage in the aforementioned activities as well as entities who sell/deposit gold to the Central Bank of Mongolia. Prior to the Amendment, the Royalty applied to mineral license holders only.

On 28 June 2019, the Constitutional Court reviewed the Amendment as per a claim that "the Amendment did not conform to concepts and principles under the Constitution of Mongolia as it causes economical pressure and curtails normal conduct of business in Mongolia by imposing double taxation."

Upon review, the Constitutional Court concluded that the Amendment was unconstitutional, effectively repealing the same. The Court's reasoning was that the Amendment was in breach of Article 5.4 of the Constitution** which states "*The State [. . .] shall regulate the economy of the country for the purpose of ensuring development of all types of enterprises as well as social development of its population,*" and Article 19.1 of the Constitution which states that "*The State shall be responsible to the citizens for the creation of economic, social, legal and other guarantees ensuring human rights and freedom.*" In other words, the Constitutional Court deemed that the Amendment violated the Government's constitutional duties to create a friendly business environment and ensure economic development.

* The Law of Mongolia on Minerals ("**Minerals Law**") enacted on 8 July 2006.

** The Constitution of Mongolia ("**Constitution**") enacted on 13 January 1992.

TAX AND LEGAL ALERT

Mongolia • Issue 01/2020 • February 2020

On 16 July 2019, the Parliament reviewed the said conclusion of the Constitutional Court and issued the Parliamentary Resolution No. 70, under which the Parliament decided to accept the Constitutional Court's conclusion to repeal the Amendment.

Consequently, on 30 October 2019, the full seat of the Constitutional Court reviewed the above-mentioned Parliamentary Resolution No. 70 and the Amendment. The Constitutional Court resolved that the Amendment was unconstitutional and repealed both the Amendment and the Parliamentary Resolution No. 70.

Following the Constitutional Court's decision, on 22 November 2019, the Parliament passed another amendment to the Minerals Law ("**2nd Amendment**") regarding the same provisions of the Minerals Law. The 2nd Amendment clarified that the Royalty will be applied on selling, transporting for selling or using minerals as it was provided by the 1st Amendment. However, the Royalty will not be applied twice on a transaction if a payer undertakes the above activities simultaneously. Also 2nd Amendment updated progressive Royalty rates for different types of minerals. The Government is mandated to approve a guideline on how the Royalty will be assessed, imposed and reported.


As per the 2nd Amendment, the following entities are subject to paying the Royalty (same as the 1st Amendment):

- (i) mineral license holders
- (ii) mineral exporters
- (iii) Entities who sell/deposit gold to the Central Bank of Mongolia.

As per the implementation Law, a provision defining entities subject to the royalty of the 2nd Amendment shall apply retrospectively during 30 October and 25 November 2019.

Should you have more questions with this regard, please do not hesitate to contact us.

* The Law on Implementing the 2nd Amendment ("**Implementation Law**") enacted on 22 November 2019.



ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 01/2020 • 2020 оны 2-р сар

**Ихээхэн шүүмжлэл
дагуулсны эцэст УИХ-
аас ашигт
малтмалын нөөц
ашигласны төлбөрийн
зохицуулалтад
өөрчлөлт орууллаа.**

Холбогдох хаяг:

Майк Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@kz.pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@mn.pwc.com

Марина Тарнавска

Ахлах Менежер, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tarnavska.maryna@mn.pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Прайсуотерхаускүперс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол Улс
Утас: +976 70009089
Факс: +976 11 322068

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2019 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.
All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



Улсын их хурал Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмал ашигласны төлбөрийн талаар нэмэлт өөрчлөлтийг баталлаа

2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын их хурал (цаашид “УИХ” гэх) АМХ*-д нэмэлт өөрчлөлт (цаашид “Нэмэлт өөрчлөлт” гэх) оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр АМХ-ийн 47 дүгээр зүйл буюу ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан этгээд болон Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (“Төлбөр”)–ийн талаарх зүйл, заалтыг хамарсан. Түүнчлэн Төлбөр төлөгч этгээд гэдэгт зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч төдийгүй дээр дурдсан үйл ажиллагааг явуулдаг аж ахуйн нэгжүүд Төв банкинд алт тушаасан этгээдүүдийг тус тус хамруулсан. Нэмэлт өөрчлөлт орохоос өмнө зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид Төлбөр төлөх үүрэгтэй байсан.

2019 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Нэмэлт өөрчлөлт нь “Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эдийн засагт дарамт учруулсан, давхар татвар ногдуулсан, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хаасан, нийгмийн эдийн засгийн хөгжилд саад учруулсан” гэх гомдол, мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэц Нэмэлт өөрчлөлтийг хянан хэлэлцсэн.

Үндсэн хуулийн цэц Нэмэлт өөрчлөлтийг хянаж үзээд Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн холбогдох зүйл заалтыг хүчингүй болгосон. Үндсэн хуулийн цэцийн үндэслэх хэсэгт дурдсанаар тус Нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн** Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг тус тус зөрчсөн гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, Нэмэлт өөрчлөлтөөр төр нь бизнес эрхлэх таатай орчин үүсгэх, эдийн засгийн хөгжлийг хангах үүргээ зөрчсөн гэж үзсэн байна.

* 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хууль (цаашид “АМХ” гэх).

** 1992 оны 1-р сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “УХ” гэх).

ТАТВАР БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс • Дугаар 01/2020 • 2020 оны 2-р сар

2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр УИХ Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг хэлэлцэж 70 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолоор УИХ Үндсэн хуулийн цэцийн Нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзсэн байна.

Үүний дараагаар 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр уг асуудлыг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцэж Нэмэлт өөрчлөлт нь Үндсэн Хууль зөрчсөн гэж үзэн Нэмэлт өөрчлөлт болон дээр дурдсан УИХ-ын 70-р тогтоолыг тус тус хүчингүй болгосон.

Үндсэн хуулийн цэцээс магадлал гарсны дараагаар буюу 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, УИХ хуралдаж АМХ-д дахин нэмэлт өөрчлөлт (цаашид “**Хоёрдахь нэмэлт өөрчлөлт**” гэх) оруулсан. Энэхүү Хоёрдахь нэмэлт өөрчлөлт нь анхны Нэмэлт өөрчлөлтийн адил худалдсан, худалдахаар ачуулсан болон өөрийн хэрэгцээнд ашигласан бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар заасан байна. Харин татвар төлөгч нь дээр дурдсан үйл ажиллагааг нэгэн зэрэг явуулсан бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулн ногдуулахгүй. Мөн Хоёрдахь нэмэлт өөрчлөлтөөр өөр өөр төрлийн ашигт малтмалуудад ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг шинэчлэн тогтоосон. Засгийн газар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг батална.

Хоёрдахь нэмэлт өөрчлөлтийн дагуу доорх этгээдүүд нь Төлбөр төлөгч байна (анхны Нэмэлт өөрчлөлтөд заасантай адил). Үүнд:

- (i) ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид;
- (ii) ашигт малтмал экспортолсон этгээд;
- (iii) Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд.

Дагаж мөрдөх журмын тухай хуульд* зааснаар 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд Хоёрдахь нэмэлт өөрчлөлтөд заасан төлбөр төлөгчийг тодорхойлсон заалт нь буцаж үйлчилнэ.

Энэхүү мэдээлэлд дурдсан асуудлаар тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.

*2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (цаашид “**Дагаж мөрдөх журмын тухай хууль**” гэх).

